

## “МАХ ИМПЭКС” ХК-ИЙН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Илтгэгч: Ж.Чинзориг “Мах импэкс” ХК-ийн ТУЗ-ийн дарга

2019 оны 04 дүгээр сарын 26


**Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, урилгаар оролцож байгаа эрхэм хүндэт зочид та бүхэнд энэ өдрийн мэндийг Мах импэкс ХК-ийн нийт ажилтан, ажилчдын өмнөөс болон хувиасаа хүргэж байгааг хүлээн авна уу.**

Мах импэкс ХК-ийн ТУЗ-өөс 2018 онд хийсэн ажлын тайлангаа та бүхэнд танилцуулан хэлэлцүүлж та бүхний гаргасан үнэтэй санал санаачлага, шүүмжлэлийг 2019 оныхоо ажилд тусган хэрэгжүүлэх болно.

Өнгөрсөн онд тайлангийн хурлаар тавьсан зорилтуудыг ханган биелүүлэх зорилгоор бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа хийж компанийн хэмжээнд бизнес төлөвлөгөө, техник зохион байгуулалтын төлөвлөгөө гарган ТУЗ-ийн хурлаар батлуулж мөрдөн ажиллаа.

Бид МУ-ын Засгийн газар, Хүнс хөдөө аж ахуйн салбараас гаргасан бодлого, хөтөлбөрийн хүрээнд үйлдвэрийн үйл ажиллагааг нийцүүлэн салбартаа тэргүүлэх чиглэлийг баримтлан ажиллаж ирлээ.

Засгийн газраас “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийг баталж, малын гаралтай түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог боловсронгуй болгох зорилт тавьсан. Мөн Малын генетик нөөцийн тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Мах, сүүний анхдугаар аяныг хэрэгжүүлэх хүрээнд малын эрүүл мэндийг сайжруулах, баталгаажуулах бүртгэлжүүлэх, үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, сүүний хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор ХХААХҮЯ-наас төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, олон улсын төслүүдтэй хамтран зохион байгуулж "Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээ, мөшгих тогтолцооны загвар арга хэмжээ"-г хэрэгжүүлж байна. Манай компани эдгээр ажлуудтай уялдуулан дотоодын зах зээлд худалдаалах мах махан бүтээгдэхүүний гарал үүслийг бүртгэлжүүлэх иж бүрэн багаж тоног төхөрөөмжийг суурилуулан энэ оноос хэрэгжүүлж эхлэхээр бэлтгэл ажлаа хангаад байна.



Малын гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн эргэн мөшгих тогтолцооны ачаар, хэрэглэгч ухаалаг гар утасны “Мал эмнэлгийн гэрчилгээний систем аппликэйшн”-ыг ашиглан тухайн махан бүтээгдэхүүн дээрх зураасан кодыг уншуулахад аль аймаг, сумаас бэлтгэсэн мах болохыг, тухайн

малыг ямар мал эмнэлэг хариуцаж байсныг, аль үйлдвэрт, хэзээ төхөөрснийг мэдэх боломжтой болж байгаа юм.

## НЭГ. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 44 дүгээр тэмдэглэл, 2017 оны 12 дүгээр сарын 04-ний өдрийн “Гэрээ байгуулах эрх олгох тухай” А-154 дүгээр тушаалыг тус тус үндэслэн малд мах бэлтгэлийн ажлыг эрчимтэй зохион байгуулах, махны үйлдвэр, малчдын хооронд гэрээ байгуулан борлуулалт хийх ажлыг хэрэгжүүлэх ХХААХҮЯ-тай “МАЛ МАХ БЭЛТГЭХ, МАХНЫ НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ, ТҮҮНИЙГ ХАДГАЛАХ, ХУДАЛДАН БОРЛУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ ГЭРЭЭ”-г байгуулан гэрээгээр хүлээсэн үүргээ амжилттай биелүүлж ажиллалаа.

Уг гэрээний дагуу:

- Хонины мах 267.3 тонн
- Ямааны мах 284.4 тонн
- Үхрийн мах 136.1 тонн

Бүгд 687.8тонн мах бэлтгэж нөөцлөн 2018 оны хавар зарж борлуулан гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн байна. Үүнээс гадна хиамын үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулж нийт 1488,1 тонн мах үйлдвэрийн аргаар бэлтгэсэн байна.

2016 онд эхэлсэн “Малчдыг дэмжих хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн тайлант оны 10 дугаар сараас эхлэн “Ямаа дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж нийт 506,1 сая төгрөгийн санхүүжилтээр хөдөө орон нутагт баг томилон ажиллаж малчдын гар дээрээс 7392 толгой ямааг худалдан авч 125,3 тн махыг бэлтгэсэн.

### БЭЛТГЭСЭН НИЙТ МАХНЫ ХЭМЖЭЭ

ХХААХҮЯ-Махны нөөц бүрдүүлэх	687,8 тн
Дотоодын зах зээлд борлуулахаар	849,4 тн
ХКҮ-ийн хэрэгцээнд	1488,1 тн

**Нийт 3025,3 тн мах бэлтгэсэн.**

ЗХЖШ болон ШШГЕГ-ын тендер шалгаруулалтанд орж тэнцэн ЗХЖШ-д үхрийн мах 12.0 тн, ямааны мах 80.0 тн, адууны мах 5.0 тн нийт 97.0 тн мах, ШШГЕГ-т үхрийн мах 30.0 тн, хонины мах 30.0 тн, адууны мах 9.5 тн, дотор махан таташ 74.0 тн, Баянгол зочид буудал ХК-д 44.3 тн махыг тус тус нийлүүлсэн байна.

ХХААХҮЯ-наас зарласан адууны мах экспортлох тендер шалгаруулалтанд оролцож 7400 тн адууны мах экспортлох квот авч экспортонд гаргасан байна.

ИБНИУ-д 1000 тн хонины мах экспортонд гаргахаар төлөвлөсөн хэдий ч дэлхийн улс төрийн нөлөөллийн улмаас дээрх ажил бүрэн хэрэгжиж чадаагүй ба 12 сард 75.0 тн хонины махыг экспортонд гаргасан.

Үйлдвэрийн мэргэжлийн онцлогоос шалтгаалж Хужирт рашаан сувилалд 25 хүн амрааснаас тус компанид олон жил үр бүтээлтэй ажилласан өндөр настан 10 хүн амарчээ. Үйлдвэрчний эвлэлийн хороо нь Хөвсгөл далайн аялалд 2 хүн, Итгэлт хамбын аялалд 2 хүн амраасан. Мөн өрх толгойлсон, амьжиргааны түвшин доогуур 3-н өрхөд түлээ нүүрсний мөнгө олгосон.

Тайлант онд тус компанид олон жил үр бүтээлтэй ажилласан ажилтнуудаас Алтан гадас одонгоор 4 ажилтан, Хөдөлмөрийн хүндэт медалиар 9 ажилтан үүнээс өндөр настан 1 хүн тус тус шагнагдсан.

Хэрэглэгчийг эрүүл хүнсээр хангах бодлогын дагуу үйлдвэрт НАССР стандартыг нэвтрүүлэх 9 гишүүнтэй багийг томилон ажиллаж байгаа ба эдгээр хүмүүсийг 8 удаагийн 16 багц цагийн сургалтанд хамруулан мэдлэг мэдээлэл олгон цаашдын хэрэгжүүлэх ажлын үндсийг тавьсан.

Тайлант онд лаборатори нь мах махан бүтээгдэхүүн болон ажилчдын цайны газрын хоолны чанарт хяналт тавих, сорилт шинжилгээг МУ-ын стандартын арга, аргачлалын дагуу орчин үеийн багаж тоног төхөөрөмж, түргэвчилсэн тестийн аргуудтай хослуулан гүйцэтгэж байна. Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлагын дагуу лабораторийн итгэмжлэлд хамрагдах зорилго тавьж ажилласнаар дараах ажлуудыг хийсэн.

- Лабораторийн ажилтнуудын өрөөг шинэ оффис тавилгаар тохижуулсан.
- Лабораторид микроскоп, хатаах шүүгээ, автоклав, термостат зэрэг 20 сая төгрөгийн шаардлагатай багаж төхөөрөмжийг шинээр авч суурилуулсан.
- MNS ISO/IEC 17025-2018 “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавигдах ерөнхий шаардлага” стандартын дагуу лабораторийн итгэмжлэлд бэлтгэн СХЗГ-т итгэмжлүүлэхээр хүсэлт гарган өргөдлөө өгсөн.

***Тайлант онд дараах хөрөнгө оруулалтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн:***

ИБНИУ-д хонины мах экспортлох ажлыг түргэн шуурхай зохион байгуулах, мал бэлтгэлийн ажлыг эрчимжүүлэхийн тулд БНХАУ-аас 280.0 сая төгрөгөөр 2 ширхэг том оврын мал ачих машин худалдаж авсан.



Ашиглахгүй байсан  $-30^{\circ}\text{C}$ -ийн хөргөлтийн системийг шинэчилж БНХАУ-аас 325,7 сая төгрөгийн сэлбэг, тоног төхөөрөмж авч  $-40^{\circ}\text{C}$ -д түргэн хөлдөөх системийг ашиглалтанд оруулсан.

Нэг ээлжинд 2000 тн мах чанах хүчин чадал бүхий 4 ширхэг уурын тогоо худалдан авч мах чанах цехийг ашиглалтанд оруулж цахилгаан болон агааржуулалтын системийг шинээр хийж нийт 20 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.

Хөргөх үйлдвэрийн подваль болон 1,2,3,4 давхар болон бод бог малын нядалгааны цехүүдэд иж бүрэн хяналтын камер суурилуулсан байна.

Нядалгааны бэлтгэл ажлын хүрээнд богийн мал нядалгааны цехд урсгал засвар хийж мозайкан шал хийсэн ба галлерейн модон цонхнуудыг вакуум цонхоор сольсон.

Эрчим хүчний удирдах газартай хамтран гадны байгууллагаар эрчим хүч хэмнэх аудит хийлгэн зөвлөмж гаргуулж, цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж доорхи ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Эрчим хүч хэмнэх ач холбогдол, түүний үр ашгийг нийт ажилчдад танилцуулан сурталчилж сургалт зохион байгуулсан

- МБҮ-ийн бүх чийдэнг лед гэрлээр олих ажилд 9.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж чийдэнг сольсноор 34.1 сая төгрөгийн хэмнэлт гаргасан.
- Цэвэр усны энгийн шахуургыг халж 22 квт-ын шахуургаар сольсон бөгөөд энэ ажилд 10,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж хэрэгжүүлснээр 16,2 сая төгрөгийн хэмнэлт гаргасан.
- Эрчим хүчний хэмнэлт хийх шаардлагатай газруудыг тоолууржуулах ажлын хүрээнд 0,56 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

### **ХОЁР. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР**

Тайлант онд компанийн зүгээс санхүү, эдийн засгийн үйл ажиллагааг сайжруулах, нэмэгдүүлэх зорилгоор бизнес төлөвлөгөө боловсруулан орлого үр ашгийг нэмэгдүүлэх зардлыг зохих төвшинд барих зорилт тавин ажилласан. Тус компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн аудитын хороо 2018 оны санхүүгийн тайлангийн эдийн засгийн үзүүлэлтэд судалгаа хийсэн ажлын дүнгээр хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

Компанийн 2018 оны санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг 2017 оны үзүүлэлттэй харьцуулж судалгаа хийхэд:

Балансын үзүүлэлт	2017он	2018он	ХЭВТЭЭ ШИНЖИЛГЭЭ	
			төгрөгөөр	хувиар
<b>Эргэлтийн хөрөнгө</b>				
Мөнгөн хөрөнгө	104,268,617.51	219,445,022.78	115,176,405.27	110%
Богино хугацаат авлага	6,774,131,258.87	6,654,008,228.06	-120,123,030.81	-2%
Татвар, НДШ-ийн авлага	86,642,583.01	24,941,770.80	-61,700,812.21	-71%
Бараа материалын нөөц	1,000,502,592.78	2,040,553,070.46	1,040,050,477.68	104%
Урьдчилж төлсөн зардал тооцоо	8,996,700.00		-8,996,700.00	
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>				
Үндсэн хөрөнгө	1,874,351,673.99	2,358,450,827.43	484,099,153.44	26%
Биет бус хөрөнгө	4,810,351.40	4,810,351.40	0.00	0%
<b>Богино хугацаат өр төлбөр</b>			0.00	
Дансны өглөг	5,481,432,157.04	6,155,551,557.16	674,119,400.12	12%
Цалингийн өглөг	30,699,858.00	38,903,201.00	8,203,343.00	27%
Татварын өр	22,712,591.82	42,852,189.96	20,139,598.14	89%
<b>НДШ-ийн өглөг</b>	<b>-4,090,421.10</b>	<b>2,809,896.29</b>	6,900,317.39	

Шинжилгээгээр:

Санхүүгийн үйл ажиллагааны нэг гол үзүүлэлт бол эргэлтийн хөрөнгө ба түүний эх үүсвэр байдаг. Эргэлтийн хөрөнгө түүний хүрэлцэхүйц шинж байдал нь компанийн үйл ажиллагааг тогтвортой явуулахад оршдог. Тус компанийн эргэлтийн хөрөнгө өмнөх оноос 964,4 сая төг-өөр өссөн үзүүлэлэлттэй байна. Үүнээс түргэн эргэх хөрөнгө 219.4 сая төгрөг, боломжит эргэх хөрөнгө 6 678.9 сая төгрөг байна. Үүнээс харахад Түргэн болоод боломжит эргэлтийн хөрөнгө нь компанийн жилийн

үйлдвэрлэлийн үйл ажиллагааг жигд хэвийн явуулахад хүрэлцэхүйц байна. Иймээс компани 2019 онд борлуулалт үр ашигаа нэмэгдүүлэхийн тулд илүү ажиллах шаардлагатайг харуулж байна. Дансны авлага 120.0 сая төг-өөр буурсан нь компаниас авлага барагдуулах тал дээр тодорхой үе шаттай үйл ажиллагаа явуулсны үр дүн юм. 2019 онд компани борлуулалт үр ашигнэмэгдүүлэх, үйлдвэрлэлээ хэвийн явуулах үүднээс 810.0 сая төг-ийнхөрөнгө оруулалтыг хийсэн.

Эргэлтийн хөрөнгийн нийт дүнд голлох байр суурийг бараа материал эзэлж байгаа нь компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл онцлогтой холбоотой бөгөөд хувийн жин нь 1 дахин өссөн нь бараа материалын нөөцийг бүрдүүлж чадсан явдал юм.

Дансны өглөгийг урьд оноос 674.1 сая төг-өөр өссөн нь бараа материалын нөөц бүрдүүлэхтэй холбоотой байна. Мөн дээр нь бараа, бэлэн бүтээгдэхүүний хангалттай эх үүсвэртэй байгаа нь эерэг үзүүлэлтээ. Хөрөнгийн хөрвөх чадварын харьцааг дээшлүүлэхийн тулд компани дээр дурдсанчлан зардлаа бууруулж ашгийн түвшинг нэмэгдүүлэх нь зах зээлийн тогтворгүй байдалд бага өртөх, үйл ажиллагааг хэвийн явуулах боломжтой болох юм.

Компанийн хувьд өөрийн үйл ажиллагаагаа тасралтгүй хэвийн явуулж байгаа мөн зах зээлд өөрийн гэсэн байр сууриа нэгэнт олсон, бусад ижил төрлийн мал, мах бэлтгэх үйл ажиллагаа явуулдаг компаниудын дунд хүчтэй өрсөлдөгчдийн нэг гэдэг утгаараа цаашид илүү их амжилттай ажиллаж үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулж чадах нь харагдаж байна.

Орлого, үр дүнгийн тайланд борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, хүүгийн болон татварын зардлууд нь ашгийн зохих шатлалд хэрхэн нөлөөлж буйг дүгнэвэл:

Үзүүлэлт	2017 он	2018 он	Хэвтээ шинжилгээ	
			төгрөгөөр	хувиар
<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>10,325,984,391.84</b>	<b>39,081,050,089.80</b>	28,755,065,697.96	2,8 дахин
Борлуулалтын өртөг	9,826,706,192.09	38,305,193,393.39	28,478,487,201.30	2,9 дахин
<b>Нийт ашиг ( алдагдал )</b>	<b>499,278,199.75</b>	<b>775,856,696.41</b>	276,578,496.66	55.40%
Үйл ажиллагааны бусад орлого	2,244,006,013.76	2,585,564,764.02	341,558,750.26	15.22%
Үйл ажиллагааны зардлын дүн	<b>2,346,743,315.74</b>	<b>2,495,528,761.54</b>	148,785,445.80	6.34%
Борлуулалт, маркетингийн зардал	10,655,103.06	80,773,526.83	70,118,423.77	6.8 дахин
Ерөнхий ба удирдлагын зардал	435,755,092.40	539,916,432.25	104,161,339.85	23.90%
Бусад зардал	1,900,697,738.09	1,873,866,183.41	-26,831,554.68	-1.41%
<b>Гадаад валютын ханшийн зөрүүний олз ( гарз )</b>	<b>-364,617.81</b>	<b>972,619.05</b>	1,337,236.86	
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>395,811,662.15</b>	<b>867,837,936.99</b>	472,026,274.84	119.26%
Орлогын татварын зардал	41,059,187.49	89,283,171.27	48,223,983.78	117.45%
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>354,752,474.66</b>	<b>778,554,765.72</b>	423,802,291.06	119.46%

Тайлант онд тус компани үндсэн үйл ажиллагаандаа голлон анхаарч ажилласны үр дүнд ашигт ажиллагаа 775,8 сая төг-өөр өссөн нь чанарын үзүүлэлт юм. 2018 онд борлуулалтын орлого 2.7 дахин буюу 28 755.0 сая төг-өөр өссөн байна. Борлуулалтын орлогыг дагаад борлуулалтын өртөг, зардал өсөх нь зүйн хэрэг, гэхдээ 2017 онд борлуулалтын өртгийн хувийн жин 95% байсан бол 2018 онд 98% болж өссөн нь борлуулалтаа нэмэгдүүлэх үзүүлэлт бөгөөд борлуулалтын дараах ашиг 2% болсон. Энэ нь тус онд компанийн борлуулалтын 60%-ийг экспорт эзлэх бөгөөд мад, махны үнийн өртөгийн өсөлт, махны худалдах үнэ экспортлогч оронд тогтвортой байсан явдал юм.

Борлуулалтын дараах ашиг нэмэгдсэн, үйл ажиллагааны зардал 147.0 сая төг буюу 6%-иар өссөн байна. Энэ нь борлуулалтын орлого 2.7 дахин өсөхөд үйл ажиллагааны зардлыг өсгөлгүй бууруулж чадсан нь компаниас өртөг, үйл ажиллагааны зардлаа бууруулах зорилт тавин ажилласны үр дүнг илтгэж байна.

Компани 2017 онд орлогын албан татварт 89.2 сая төгрөг төлж өөрт үлдэх ашиг 778.5 сая төгрөг-өөс хувьцаа эзэмшигчдэд ноогдол ашиг болгон 456.0 сая төг-ийг хувиарлах бололцоотой байна гэдэг дүгнэлтийг ТУЗ-өөс өгсөн. Тус компани 2017 онд өмнөх онуудын ноогдол ашигт 48.0 сая төгрөгийг олгосон байна.

Тайлант оны ажлын үр дүнгээс үзэхэд тус компанийн бизнесийн үйл ажиллагаа нилээд идэвхижиж үндсэн үйл ажиллагааны орлого нэмэгдэн ашигт ажиллагааны түвшин дээшилж байгаа нь цаашид төлбөрийн болон өөрийн хөрөнгө капиталын чадавхиа сайжруулах нөхцөл бүрдэж байна.

### ***ГУРАВ. КОМПАНИЙН ЦААШДЫН ЗОРИЛТ***

Үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэхэд гадаад экспортыг нэмэгдүүлэхийн тулд дараах ажлуудыг гол зорилт болгон ажиллана. Үүнд:

- “Малчдыг дэмжих” хөтөлбөрийг үргэлжлүүлэн зохион байгуулах
- Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах, махан бүтээгдэхүүний гарал үүслийг баталгаажуулах тогтолцоог хэрэгжүүлэх ажлыг ХХААЯ, холбогдох газруудтай хамтран зохион байгуулах
- Хиам болон хагас боловсруулсан бүтээгдэхүүнд хэрэглэгдэх махны 80 хувийг өөрийн үйлдвэрт бэлтгэсэн махаар хангана.
- Ажилтан албан хаагчдыг ээлж дараатайгаар мэргэшүүлэх сургалтад тогтмол хамруулах замаар боловсролын түвшинг байнга ахиулан ажиллах. Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд төлөвлөгөөт ажлуудыг тогтмол хийх.
- Цахилгаан эрчим хүч хэмнэх төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хийх.
- Батлагдсан засварын төлөвлөгөөний дагуу үйлдвэрийн техник технологийг шинэчлэх ажлыг цаашид үргэлжлүүлэн хийнэ.
  - Бод мал төхөөрөх цехэд мозайкан шал хийх /1152м<sup>2</sup> талбай шаардлагатай хөрөнгө 45,6 сая төгрөг/
  - Эхлэн боловсруулах үйлдвэрийн барилгын гадна талыг сэндвичээр дулаалах, 1-р давхрын цонхнуудыг солих. Гадна талаас нь давхар хоорондын зайг сэндвичээр дулаалах /1296 м<sup>2</sup> талбай шаардагдах хөрөнгө 135 сая төгрөг/
  - Дотор эрхтэн, дайвар бүтээгдэхүүн боловсруулах цехийн дотор засвар /540 м<sup>2</sup> талбай шаардагдах хөрөнгө 53,6 сая төгрөг/
  - Эхлэн боловсруулах үйлдвэрийн шатны хонгилын засвар /172 м<sup>2</sup> талбай шаардагдах хөрөнгө 27,1 сая төгрөг/
  - Тоног төхөөрөмж шинэчлэлийн засвар шаардагдах хөрөнгө 87,2 сая төгрөг, үүнээс:
    - Сантехникийн засвар 30.0 сая төгрөг
    - Цахилгааны засвар 4,7 сая төгрөг
    - Тоног төхөөрөмжийн засвар 48,0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөн ажиллаж байна.
- Лаборатори нь 2019 онд үйл ажиллагаа, хүрээгээ улам өргөжүүлэн ажиллаж, итгэмжлэл авах

Хувьцаа эзэмшигч та бүхэн Махимпэкс ХК-ийн 2019 оны үйл ажиллагаа, цаашид тавих зорилтод үнэтэй санал гаргана гэдэгт итгэж байна.

Та бүхэнд ажил хөдөлмөрийн амжилт эрүүл энх сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

**АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА**